



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 240


Улаанбаатар
хот

Тамирчин, дасгалжуулагчдад мөнгөн
шагнал олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 20.3.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "ТОКИО-2020" зуны XXXII олимпын наадамд амжилттай оролцож мөнгөн медаль хүртсэн тамирчин Сaeид Моллаей, хүрэл медаль хүртсэн тамирчин Мөнхбатын Уранцэцэг, Цэнд-Очирын Цогтбаатар, Бат-Очирын Болортуяа, дасгалжуулагч Халиуны Болдбаатар, Мөнхбаатарын Бундмаа, Бямбажавын Баттулга нарыг хавсралтад заасан мөнгөн шагналаар шагнасугай.

2. Мөнгөн шагналд шаардагдах 225,000,000.0 (хоёр зуун хорин таван сая) төгрөгийг Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны батлагдсан төсвөөс зохих журмын дагуу гаргахыг Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
Эрхлэх газрын дарга

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2021 оны 240 дүгээр
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

**"ТОКИО-2020" ЗУНЫ ХХХII ОЛИМПЫН НААДАМД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ
МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИН, ДАСГАЛЖУУЛАГЧДАД ОЛГОХ
МӨНГӨН ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ**

(сая.төгрөг)

№	Тамирчны нэрс	Жин зай, төрөл	Медаль	Мөнгөн шагналын дүн	Тивийн оролцоо	Тивийн оролцооны хувь	Тивийн хувь тооцсон мөнгөн дүн	Оролцсон орны тоо	Оролцсон орон тооцсон хувь	Тамирчин (дасгалжуулагч)-д олгох мөнгөн шагналын хэмжээ
"ТОКИО-2020" Зуны Олимпын ХХХII наадам ЖУДО БӨХ										
1.	Саеид Моллаей	81 кг	Мөнгө	60,000,000	-	100	60,000,000	-	100	60,000,000
2.	Мөнхбатын Уранцэцэг	48 кг	Хүрэл	30,000,000	-	100	30,000,000	-	100	30,000,000
3.	Цэнд-Очирын Цогтбаатар	73 кг	Хүрэл	30,000,000	-	100	30,000,000	-	100	30,000,000
4.	Халиуны Болдбаатар	Дасгалжуулагч							50	45,000,000
5.	Мөнхбаатарын Бундмаа								50	15,000,000
"ТОКИО-2020" Зуны Олимпын ХХХII наадам ЧӨЛӨӨТ БӨХ										
6.	Бат-Очирын Болортуяа	53 кг	Хүрэл	30,000,000	-	100	30,000,000	-	100	30,000,000
7.	Бямбажавын Баттулга	Дасгалжуулагч							50	15,000,000
Нийт										225,000,000